

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шивээговь сумын “3 дугаар сургууль”-ийн  
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2020/50/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойр хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn Аудитор: Д.Оюунбат Утас: 70543179 Цахим хаяг: Oyuna200702@yahoo.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АИТХТ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11-14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	15-24



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2020.02.27 № 43

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Шивээговь сумын "3 дугаар сургууль"-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Шивээговь сумын "3 дугаар сургууль"-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шивээговь сумын "3 дугаар сургууль"-ийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус газарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн

098020155

болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шивээговь сумын "3 дугаар сургууль"-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3.1. ХХОАТ-ЫН ТАЛААР

#### Илрүүлэлт

Тайлант онд ХХОАТ-ын хөнгөлөлтийг 834.2 мянган төгрөгөөр дутуу, 2,327.4 мянган төгрөгөөр илүү тооцож, авлага, өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, ХХОАТ-ын тухай хуулийн 24.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна

#### Хариуцах ажилтан

Захирал Д.Буяндэлгэр  
Нягтлан бодогч О.Сувданцэцэг

#### Эрсдэл

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдах, ажилчид хуулийн дагуу хөнгөлөлтөө эдлэж чадахгүйд хүрэх

#### Зөвлөмж

ХХОАТ-ын хөнгөлөлтийг хуулийн дагуу үнэн зөв тооцож, алдааг давтан гаргахгүй байх, авлага, өглөгийг барагдуулж ажиллах

#### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

### 3.2. Үндсэн хөрөнгийн талаар

#### Илрүүлэлт

Ашиглалтын хугацаа дууссан болон анхны өртгөө нөхсөн 78 нэр төрлийн 1,859 ширхэг, 169,491.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 12 дугаар зүйлийн 12.1, 18 дугаар зүйлийн 18.1, ТӨБЗГ-ын 2019.06.18-ний өдрийн 271 тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2.1, 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

#### Хариуцах ажилтан

Захирал Д.Буяндэлгэр  
Нягтлан бодогч О.Сувданцэцэг

#### Эрсдэл

Тайлангийн үнэн зөв байдлыг алдагдуулах

#### Зөвлөмж

Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг акталж устгах буюу дахин үнэлж бүртгэх

#### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

### 3.3. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар

#### Илрүүлэлт

Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн /бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 212,996.8 мянган төгрөгийн барилгын дээвэр, дулааны шугам, бараа материалын дансанд төсөл дуусаагүй гэдгээр бүртгэсэн 22,950.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө/ байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

#### Хариуцах ажилтан

Захирал Д.Буяндэлгэр  
Нягтлан бодогч О.Сувданцэцэг

#### Эрсдэл

Тайлангийн үнэн зөв байдлыг алдагдуулах

#### Зөвлөмж

Хөрөнгийг зөв ангилж, нягтлан бодох бүртгэлд тусгах

#### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Ахлын баримтын нэр:

Залруулаагүй буруу шгэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл

Ахлын баримтын дугаар:

Б501

Аудитын код: ГСА-2020/50/СТА-ТШЗ

мянган төгрөгөөр

Аудитын нэр:

Шивээговь сумын "З дугаар сургууль"

Тоо	Аудитын чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн / мянган төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Зөвшөөрсөн санвал, тайлбар	Аудит хийгээсэн байгууллагын өгсөн харуу, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн харуу, тайлбар	Гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Авлага	Нийгмийн даатгалын зардал дутуу тайлагнасан	376.0	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулсан	Залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
2	Зардал	Нийгмийн даатгалд ажилчдын цалин дутуу тайлагнасан	554.6	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулсан	Залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
3	Зардал	Цалингийн зардал илүү тайлагнаан	823.1	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулсан	Залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
4	Зардал	Лист цалинтай давхардуулан олгосон	199.5	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулсан	Залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
5	Зардал	Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг дутуу тайлагнасан	1,736.2	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулсан	Залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
6	Зардал	ХХОАТ-ын хөнгөлөлтийг 834,2 мянган төгрөгөөр дутуу, 2,327,4 мянган төгрөгөөр илүү тооцсон	3,161.6	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулсан	Залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
7	Зардал	Акталах шийдвэр гарсан үндсэн хөрөнгийн данснаас дутуу хассан	1,294.0	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулсан	Залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
8	Өглөг	Халаалтын зардлыг усны зардалд тайлагнасан	3,007.7	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулсан	Залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
9	Өглөг	Усны зардлыг халаалтын зардалд тайлагнасан	492.4	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулсан	Залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
10	Зардал	Ажилчдын амралтын цалинг буруу тайлагнаснаас хязгаарлалт үүсч, НДШ дутуу суугагдсан боловч бүрэн төлсөн	1,565.0	Төлбөрийн акт тогтоох	Зөвшөөрсөн			Төлбөрийн акт тогтоох	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
11	Үндсэн хөрөнгө	Зөвшөөрөлгүй худалдаж авсан үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	22,950.0	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн			Зөвлөмж өгөх	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
12	Үндсэн хөрөнгө	Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэний бусад үндсэн хөрөнгийн дансанд барилгын дээвэр засвар, дулааны шугам засвар/	212,996.8	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн			Зөвлөмж өгөх	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
13	Үндсэн хөрөнгө	Ашиглалтын хугацаа дууссан болон анхны өртөө нөхсөн 78 нэр төрлийн 1859 ширхэг, 169,491.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.	-	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн			Зөвлөмж өгөх	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
14	Үндсэн хөрөнгө	ХХОАТ-ын хөнгөлөлтийг 834,2 төгрөгөөр дутуу, 2,327,4 төгрөгөөр илүү тооцсон	-	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн			Зөвлөмж өгөх	Б.Буяндэлгэр, О.Суваданцэцэг
Нийт дүн			249,156.9						

Бэлтгэсэн:

Аудитор

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, Тэрүүлэх аудитор

Д.Оюунбат

*(Handwritten signature)*

Танилцаж зөвшөөрсөн:

Шивээговь сумын "З дугаар сургууль"

Огноо: 2020.02.2

Огноо

Огноо

Огноо

*(Red official stamp and signature)*

Огноо:

Огноо:



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 01/38

Чойр

Төлбөр тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Шивээговь сумын "3 дугаар сургууль"-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Ажилчдын ээлжийн амралтын цалинг буруу тооцсоноос хязгаарлалт үүсч, НДШ-ийн 1,565.0 мянган төгрөгийг дутуу суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20, 20.2.9 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дутуу суутгасан 1,565,034.00 төгрөгийг хавсралтад дурьдсан ажиллагсдаар төлүүлж, аймгийн Төрийн сан дахь Орон нутгийн орлогын /Төсөвт байгууллагын өөрийн орлого/ 100220000954 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 20-ны дотор гаргаж, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Шивээговь сумын "3 дугаар сургууль"-ийн захирал Д.Буяндэлгэр, нягтлан бодогч О.Сувданцэцэг нарт хариуцуулав.

	<b>ТОГТООСОН<sup>1</sup>:</b>	<b>АКТЫГ</b>	<b>ЗӨВШӨӨРСӨН:</b>
АУДИТОР:	 Д.ОЮУНБАТ	ШИВЭЭГОВЬ СУМЫН СУРГУУЛЬ-ИЙН ЗАХИРАЛ:	"3" ДУГААР
АУДИТЫН МЕНЕЖЕР:	<b>ХЯНАСАН:</b>  Г.НАРАНБАЯР	НЯГТЛАН БОДОГЧ:	Д.БУЯНДЭЛГЭР О.СУВДАНЦЭЦЭГ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

080 1000168